

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-7

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 8-24

- 
- 1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/** 9-12
- 2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/2024.05.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 12-13  
14-17
- 3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 13-14
- 4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/** 17-24

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Ёс зүй, дэгийн байнгын хорооны  
08 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 26 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганмаа;

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Д.Бум-Очир, Д.Жаргалсайхан.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал оролцов.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн газрын Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга Н.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Баярбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.12 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.12.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга Н.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 1  
Бүгд: 7  
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.13 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.13.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 1  
Бүгд: 7  
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” хэсэгт доор дурдсан агуулгатай 4.2.3.14 гэсэн дэд хэсэг нэмэх:

“4.2.3.14.Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.”

Төслийн 2 дугаар хавсралтад **13** “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхын үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “20” гэж,

“2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, 14 “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 1

Бүгд: 7

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.*

*Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсын Ерөнхий аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Ө.Ариунболор, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал

хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцох үүрэгтэй ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөр Байнгын хорооны хуралдаанд асуултад хариулж байгаа учраас хэлэлцэхээр баталсан дараалалд өөрчлөлт оруулж дараагийн асуудал болох Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхээр ТОГТОВ.

*Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 3

Бүгд: 8

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 3  
Бүгд: 8  
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.*

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/-ийг үргэлжлүүлэн хэлэлцэв.*

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу танилцуулж, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нэмэлт тайлбар хийв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Ч.Лодойсамбуу, Д.Энхтуяа, Д.Рэгдэл нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар Байнгын хорооны тогтоолын төслийн талаар уншиж танилцуулав.

**Б.Баярбаатар:** “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 6  
Бүгд: 9  
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 3  
Бүгд: 9  
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара-д “уучлалт гуйх хариуцлагыг ногдуулах нь зүйтэй” гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 0  
Бүгд: 7  
100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Б.Баярбаатар:** “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахдаа Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан “уучлалт гуйлгах” хариуцлагыг ногдуулах нь зүйтэй гэсэн горимын саналаар санал хураалгах, хэрвээ уг санал дэмжигдэхгүй бол ажлын хэсгийн бусад гишүүдийн гаргасан “сануулга өгөх” сахилгын хариуцлагыг ногдуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 4  
Бүгд: 7

42.8 хувийн саналаар горимын санал дэмжигдээгүй тул “сануулга өгөх” сахилгын хариуцлагыг ногдуулах тухай Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 13 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 69.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 41 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
14 цаг 26 минут.

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Ирц танилцуулъя.  
Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн ирц хүрсэн тул 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Баярбаатар, Ариунзаяа гишүүн ирсэн байна, Баасанжаргал гишүүн ирсэн байна. Бум-Очир гишүүн чөлөө авсан, Ганмаа гишүүн гадаад томилолттой байгаа, Жавхлан сайд, Жаргалсайхан гишүүн хоёр өөр Байнгын хороон дээр байна уу тээ? Лодойсамбуу гишүүн ирсэн байна, Очирбат гишүүн ирсэн байна, Рэгдэл гишүүн ирсэн байна, Хэрлэн гишүүн ирсэн байна. Энхтуяа гишүүн яасан юм? Түрүүн нөгөө юун дээр байсан уу?

Ирц хүрсэн учраас хуралдааныг эхэлье. Өнөөдөр хэлэлцэх 3 асуудал байна.

Нэгдүгээрт, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг.

Хоёрт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд.

Гуравт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл гэсэн гурван асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлах санал хураалт.

Шууд танилцуулаад явчих юм уу тээ? Энэ дээр сая Рэгдэл гишүүнээр ахлуулсан бүрэлдэхүүн ажилласан тийм ээ? Тэр асуудлаа ер нь өнөөдөр танилцуулах гэж байна уу одоо?

Болоогүй юу? Хэн ч ахалсан байсан яах вэ. Тэрийг болоогүй юу тээ? Өнөөдрийн хуралдаанаар.

Дараагийнх дээр үү? Дараагийнх нь хэзээ хуралдах билээ манайх? Өнөөдөр оруулчихвал яасан юм? Лодой гишүүн юу гэж бодож байна? Энийг хэлэлцэх асуудал дээр нэмчихье тэгэх үү? Нэмээд тэртээ тэргүй цааши нь их ажиллаад байх юм байхгүй юм чинь. Ингээд 4 асуудлаар хэлэлцэх асуудал орлоо.

Дэгийн байнгын хороонд ажлын хэсэг орж ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн Лхагвын Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Цэнддаваагийн Амартөгс, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын зөвлөх Цэвээндоржийн Эрдэнэбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ням-Осорын Учрал орж ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Даваасамбуугийн Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Тогоогийн Гантогтох, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга Вандансүрэнгийн Жавзан, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Намдагийн Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төлөөллийн хэлтсийн дарга Батхишигийн Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Лхагвасүрэнгийн Балчинлуvsан, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга Отгонтогтох овогтой Энхмөнх гэсэн ийм ажлын хэсэг Байнгын хорооны бүрэлдэхүүнд орж ирсэн байна.

**Хэлэлцэх асуудлын дарааллаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.**

Манай Байнгын хороонд хамрах хүрээ гэж байгаа. Энэ хүрээнд бол төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын бодлого, Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны асуудал, гишүүний ёс зүйн сахилга асуудал, чуулганы хуралдааны дэгийн асуудал, дэг сахиулах, гишүүний хөрөнгө оруулгын мэдүүлэг, Засгийн газрын гишүүний албан үүргийн хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох журмын асуудал, нэгдсэн хуралдааны ирцийн асуудал, гишүүний ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх асуудал, Улсын Их Хурлыг үл хүндэтгэх үйлдэлд хяналт тавих гэсэн ийм хүрээ манай Байнгын хороонд хамаарна.

Тэгэхээр бид хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор, хэлэлцэж байгаа асуудал дотор энэ хүрээндээ бид нар санал гаргаж хэлэлцүүлнэ. Бусад Байнгын хороод чиглэлийнхээ дагуу явж байгаа гэдгийг хэлье.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан асуух асуулт гишүүд байвал нэрээ өгнө үү. 4 заалт байгаа. Асуулттай гишүүд байна уу манайхан?

Асуулт байхгүй гэж үзэх үү?

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын

Их Хурлын тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү.

Байхгүй.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэр өгнө үү.

Алга байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгнө үү.

Байхгүй байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд зүйл бүрээр асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт гарсангүй.

Одоо зарчмын зөрүүтэй санал гаргана. Зарчмын зөрүүтэй санал гаргана. Гишүүд санал гаргах уу? Би санал гаргана. Байнгын хорооны даргын хувьд.

Нэмэлтээр тусгах 4.2.3.12 дээр “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж нэмэх,

4.2.3.13-д “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” 2024-2030 он, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүйн сахилга, хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс

суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” гэж нэмэх,

4.2.3.14-д “Төрийн албаны ёс зүй, индекс, ёс зүй, дэд бүтцийг олон улсын туршихад суурилан хэрэгжүүлнэ.” гэж нэмэх,

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад 13, 14, 15 нэмэх саналтай. Шалгуур үзүүлэлтийг уншиж танилцуулна. Энэ дээр. Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ. Шалгуур үзүүлэлт Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын үнэлгээ, хэмжих нэгж нь хувь, суурь түвшин 2024 одоогоор 0, 2025-20, 2026 онд-30, 2027 онд-40, 2028 онд-50 гэсэн ийм зорилтууд байна.

Ёс зүйн дэд хорооны тайлан мэдээллийн эх сурвалж нь мэдээлэл цуглуулах арга зүй нь Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын судалгаа. Мэдээлэл цуглуулах давтамж нь жилд 1 удаа гэсэн ийм.

Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх, соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ гэсэн үр дүн байна. Шалгуур үзүүлэлт Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн төлөөллийн үнэлгээ хувиар хэмжинэ.

Мөн батлагдсан хөтөлбөр байна. 25-30 хувь, 26 онд-50 хувь, 27 онд-75 хувь, 28 онд ийм 85 хувь үзүүлэлт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан олон эх үүсвэрээс мэдээлэл цуглуулж, харьцуулах арга зүй явна. Жил бүр мэдээллийг цуглуулна гэсэн ийм байна.

Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлэх үр дүнтэй. Шалгуур үзүүлэлт, ёс зүйн үзүүлэлт 25 онд-10 хувьтай, 26 онд-15 хувьтай, 27 онд-25 хувьтай, 28 онд-35 хувьтай. Төрийн албаны олон улсын индексийн ёс зүйн үзүүлэлт үндэсний үзүүлэлтийн судалгаа жилд 1 удаа гэсэн ийм

зорилтот түвшинүүд та бүхэнд танилцуулж байна.

Ингээд саяын миний хэлсэн зарчмын зөрүүтэй 3 санал байна. 3 саналыг заалт бүрээр нь санал хурааж, дүгнэлтэд оруулж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах саналаа гаргана.

Нэгдүгээрт, ёс зүйн хэм хэмжээг сахиулах зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ гэсэн ийм саналыг Байнгын хорооны гишүүд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Болно, түрүүн асуугаагүй байж уу? Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Саяын нөгөө нэмэлт саналтай холбоотой юу тодруулах гээд байна. Энэ манайх ер нь энэ төрийн албаны ёс зүйн индекс гэдэг юмыг манай Төрийн албаны төв зөвлөл хийдэг юм уу? Одоо хийх гэж шинэ санал гэсэн үг тээ, зөв үү тээ? Оруулах гээд байгаа гэсэн үг тээ?

**Б.Баярбаатар:** Баасанжаргал гишүүний асуултад манай Төрийн албаны зөвлөлийнхөн ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга ирсэн байна. Ер нь бид нар энэ төрийн албаны энэ ёс зүй гэдэг зүйлийг ёс суртахуун гэдэг, төрийн албан хаагчийн ёс суртахуун гэдэг зүйл дээр манай Байнгын хороо идэвхийлэн санаачилж ажиллах ёстой.

Жишээлбэл, манай Ёс зүйн хороо чинь 24 орон тоотой. Өнөөдөр 10 хүн ажиллаж байгаа тийм ээ? 2 өрөөтэй. 2 дугаар микрофоноо өгчих.

**Н.Ганбаатар:** 24 орон тоотой одоогоор 10 хүн ажиллаж байгаа.

**Б.Баярбаатар:** Тэгээд хараат бус байдал нь байхгүй.

Жишээлбэл, Байнгын хорооны даргын хувьд би өчигдөр бас нэлээн уулзалтууд хийж харлаа.

Жишээлбэл, Төрийн албаны зөвлөлийн гишүүд нь өөрсдөө ёс зүйн хорооныхоо гишүүн байж байх юм. Би хэлж байгаа шүү дээ Ёс зүйн хорооны дарга нь Төрийн албаны зөвлөлийн гишүүн байж болно, бусад нь ондоо шүү. Бусад нь өөр газраас байх ёстой. Тэгж байж энэ хараат бус зарчим чинь эдийн засгийн хувьд хараат бус байх ёстой. Төрийн албаны зөвлөлийн санхүү дээр ёс зүйн хорооных нь төсөв суугаад явахаар нөгөө хараат бус зарчим нь өөрөө үйлчлэхгүй байгаа юм.

Цаашлаад бид нар энэ Ёс зүйн хороо гээд, Монгол Улсын ёс зүйн хороо, Төрийн албан хаагчийн ёс зүйн хороо гэх юм уу? Ямар нэршилтэй байдаг юм ер нь бол тийм бие даасан байгууллага болох хэмжээнд хүртэл ажиллах ёстой юм гэж харж байгаа шүү. Тэгээд бид нар өнөөдөр авлигатай тэмцье гээд яриад байдаг. Хүнд суртлыг бууруулъя, арилгая гээд яриад байдаг, хүнийхээ хандлагын талаар ерөөсөө ярьдаггүй. Энэ ёс суртахууны талаар ерөөсөө ярьдаггүй.

Тэгэхээр цаашидаа энэ дээр манай Байнгын хороо хатуу ажиллана. Бусад Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагатайгаа ажиллана. Өнөөдөр Төрийн албаны зөвлөлийнхөн ирчихсэн байна.

Жишээлбэл, ингээд төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлдөг байдал сүүлийн үед нэлээдгүй газар авч байна шүү дээ. Зөвхөн хуулийн дагуу л асуудалд ханддаг байх ёстой. Улс төржиж биш. Тэгэхээр энэ дээр манай Төрийн албаны зөвлөл цаашидаа энэ орон нутгуудаар ингээд очихоор ажлаас халагдаж байгаа улсуудын гомдол, санал тасрахгүй байна шүү дээ.

Мэдээж хамтарсан засаг байгуулаад хамтраад ажиллаж байгаа нь зөв. Тэгэхдээ төрийн албан хаагч гэдэг

бол улс төрждөг албан тушаал биш шүү. Хуультай ийм байх ёстой. Энийг манай Төрийн албаны зөвлөлийнхөн цаашидаа анхаарч, үйл ажиллагаандаа бас хуулиа мөрдөж ажиллана шүү гэдэг зүйлийг, Авлигатай тэмцэх газар дээр ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж өгдөг байх ёстой. Тэрийгээ бас улс төржихгүй гаргадаг байх ёстой. Тэгэхээр энийг бас энэ протоколд тусгаад бас нөхцөл байдлыг сануулах нь зөв байх гэж харж байна.

Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Нэмэлт юун дээрээ Төрийн албаны төв зөвлөл Ёс зүйн хорооноос хүмүүс ирчихсэн байгаа учраас тодруулаад асуучихъя. Сая тэр бүрэлдэхүүний тухайд бас нэг талдаа бид нар анхаарах ёстой байх.

Хоёрдугаарт гэвэл юун дээр манай шүүгчид бол жишээ нь Шүүхийн ерөнхий зөвлөл тэгчхээд тусдаа Шүүхийн сахилгын хороо гээд тэгээд Сахилгын хорооны гишүүдээ бүрдүүлэх, томилох нь дахиад бүр хуулиараа шийдэж байгаа шүү дээ. Тэгэхээр яг үүнтэй адилхан яг саяын Байнгын хорооны даргын хэлдэг шиг хэрвээ энэ ажлыг ажил болгоно гэвэл Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орж таарах байх. Тэгээд дахиад нөгөө ирэх жилийн 4 жилийн үйл ажиллагаа дээр бүүр бүтцийн өөрчлөлт, тогтолцооны өөрчлөлт энэ тэр гэсэн тийм үг, үсэг юунууд бас орж таарах нь байна. Тэгэхээр би нөгөө сая таны хэлсэн 3 санал дээр, саналыг юугаар нь үгчилж хараагүй учраас тэгэхээр илүү тэр агуулгаараа бас байвал зүгээр юм болов уу гэж бодож байна.

Тэгээд Төрийн албаны төв зөвлөл, Төрийн албаны төв зөвлөлөөс юм асуугаадахъя. Ийм гомдол маш их ирдэг. Хууль бусаар ажлаас халагдсан хүмүүсийн олгож байгаа цалингийн асуудлыг нөхөн олговрын асуудлыг тухайн хууль бус шийдвэр гаргасан дарга албан тушаалтнаас 20 оноос хойш шүүхээр шийдвэрлүүлж гаргуулж байгаа.



Тэгэхээр энийг их үзэмжээрээ хэнийг шүүхэд өгөх вэ гэдэг нь үзэмжийн асуудал болсон гэдэг зүйл нэлээн яригдаад байгаа. Тэгэхээр яг энэ байдал та хэд үнэлгээ хийсэн бол 20 оноос хойш хийгдэж байгаа ажил учраас хэчнээн буруутай албан тушаалтны хэчнээн шийдвэрийг шүүхэд өгөв, түүний барагдуулалт хэдэн хувьтай байгаа вэ? Тэгээд хэний шийдвэрийг шүүхэд өгөх вэ гэдгээ та хэд ямар үзүүлэлтээр гаргаж үздэг вэ? Эсвэл хамгийн анх шийдвэр гаргасан огнооных нь дарааллаар явдаг юм уу, яадаг вэ гэсэн ийм асуулт байна гэсэн үг.

**Б.Баярбаатар:** Хариулъя. Төрийн албаны зөвлөл 2 дугаар микрофон.

**Н.Ганбаатар:** Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Би шүүхийн тэр асуудлыг бол хариулах эрх хэмжээ надад бол байхгүй байна. Би Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Төрийн албаны зөвлөлийн гишүүд яг одоо давхцаад орсон байгаа. Тэгээд хуралдаан давхцаж байгааг та бүхэнд бас танилцуулж байна.

**Б.Баярбаатар:** Ойлголоо. Хариултын дараа нь нөхөөд өгчихнө биз албан байдлаар.

Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалт явуулна. Гишүүд.

4.2.3.12-т “Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэсэн заалтыг оруулах саналтай. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 6 гишүүн дэмжиж, 85.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн 4.2.3.13-д “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс

урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” гэсэн заалтыг нэмэх саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

6 гишүүн буюу 85.7 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

4.2.3.14-д “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршилагад суурилан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 6 гишүүн дэмжиж, 85.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

Дараагийн асуудал. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Амжилт хүсье.

15.46 цаг

**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн

зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд нам, эвслийн бүлэг, төсвийн төслийг хэлэлцэнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулна.

Төрийн албаны зөвлөлөөс байна тээ? Танилцуулгыг нь Жавхлан сайд хийнэ гээд тавьчихсан байх юм энэ дээр. Жавхлан сайд нь байгаа юм уу? Манай Байнгын хорооны гишүүн биз дээ энэ хүн? Хүлээх үү тэгвэл? За хүлээнэ тэгвэл.

Ариунзаяа гишүүн горимын саналаа гаргачих. Ариунзаяа гишүүний микрофоныг өгөөрэй

**А.Ариунзаяа:** Горимын санал гаргая. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ажлын хэсэг өөр Байнгын хороонд санал, асуултад хариулж байгаа учраас хэлэлцэхээр баталсан дараалалд өөрчлөлт оруулж дараагийн асуудлыг хэлэлцэж байх горимын санал гаргаж байна.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

5 гишүүн дэмжсэн санал өгч, 71.4 хувиар санал дэмжигдлээ. Дараагийнхаа хэлэлцэх асуудалд ороод явж байя.

**Гурав дахь асуудал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах**

**тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүн байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуулттай гишүүд байна уу?

Асуулт алга байна.

Хуулийн төслийн зүйл, заалт бүрээр холбогдуулан гишүүд асуулт явуулсангүй. Санал хураалт явуулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Саналтай гишүүн байгаа юу?

Байхгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал хураана тээ? Энэ дээр горимын санал гаргана. Анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналыг оруулна. Болох уу? Зүйтэй тэгвэл санал хураалт явуулъя.

Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Энэ хуулийн хэрэгжилт хангах талаар нэмэлт, өөрчлөлт орж байгаа учраас анхны хэлэлцүүлгээр нь шууд оруулах ийм горимын санал гаргаж байна. Ямар нэгэн өөр саналууд байхгүй учраас.

**Б.Баярбатаар:** Ойлголоо. Тэгвэл горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалт 5 гишүүн дэмжиж, 62.5 хувиар санал дэмжигдлээ.

Одоо үндсэн саналаа хураана.

Ингээд анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг оруулна. Байнгын хороо анхны хэлэлцүүлгээ явж дууссан. Төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулна.

Санал хураалтад 5 гишүүн буюу 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах Ариунзаяа гишүүний санал нэмэгдээд.

Уулсын Их Хурлын чуулганд Лодойсамбуу гишүүн танилцуулна.

14.54 цаг

**Ингээд хоёр дахь асуудал руугаа эргэж орно.**

Танилцуулгыг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна. “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт тулгамдаж буй асуудлуудыг шийдэх эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд инфляцыг 1 оронтой тоонд зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, хурдтай зоригтой эрс шийдвэрүүдийг гаргаж шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

“Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Нийслэлийн Их, Бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу Go Mongolia ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог, авто замын төсөл, Шинэ Хархорин төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

Хоёрдугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжиж буй Бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

Гуравдугаарт, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах хувийн хэвшилд тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлдэг шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн. Шинэ төсвийн ерөнхийлөн захирч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 24 оны төсвийн тухай хууль төсвийн зохицуулалт хийлээ.

Тавдугаарт, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг ба ирээдүй иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжссөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ.

Үндэсний баялгийн сангийн төрөлжссөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх хуримтлал үүсэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Жавхлан сайдад баярлалаа. Ажлын хэсэг танилцуулна.

Болдын Жавхлан Сангийн сайд, Засгийн газрын гишүүн, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Өлзийсайханы Ариунболор Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Батхишигийн Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Энхболдын Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Булганхүү овогтой Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга гэсэн ийм ажлын хэсэг байна.

Дараагийн танилцуулга Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулах ёстой. Орж ирж байна уу?

**Б.Баярбаатар:** Манай асуулт асуух гишүүд ер нь нэрсээ өгч л бай. Асуух асуулттай гишүүд асуулт байна уу?

Хэрлэн гишүүн. Хэрлэн гишүүнээр ингээд тасалчихъя.

Та асуултаа асууж байх уу? Тэртээ тэргүй энэ төсөвтэй холбоотой



л байлгүй дээ? Тийм, тэгвэл асууж байя. Микрофоноо.

**Б.Хэрлэн:** Асуулт, үг гэж хоёуланг нь хамтатгаж хэлж болно. Тэгэхээр ерөнхийдөө нөгөө Ёс зүй, дэгийн байнгын хорооны яг хариуцах ажил, үүргийн хувьд бид нар их илүү их Улсын Их Хурлын гишүүдийн бас ёс зүйн байдлын тухай асуудал дээр илүү их төвлөрөөд байдаг тээ? Ер нь Ёс зүй, дэгийн байнгын хороо маань энэ Улсын Их Хурлын ялангуяа өнөөдөр бол бид нар Төсвийн тухай хууль, төсвийн тодотголоо хэлэлцэж байна, ингээд холбогдох хуулиудад оруулж ирж байгаа өөрчлөлтийн тухай ингээд хэлэлцэж байгаа ийм цаг үе. Тэгэхээр энэ Ёс зүй, дэгийн байнгын хороо маань бас ер нь эдгээр хуулиуд маань ер нь орж ирж байгаа хууль, хуулийн шинэчлэлүүд маань тодорхой хэмжээгээр хуулийнхаа үндсэн зарчимтай хэр нийцэж байна гэдэг тухай асуудал дээр ямар нэгэн маргаантай байдал үүсэхэд тэрийг хагалдаг байх үүрэг бас Ёс зүй, дэгийн хороо хүлээх үү? Ийм үүргийг би ер нь бид нар цаашид хүлээх үү, үгүй юү гэдгийг би бас та бүхнийг бодоосой гэж би бодож байна л даа. Нэг талаасаа.

Яагаад энэ ингэж хэлж байгаа юм бэ гэхээр өнөөдөр чинь ингээд сошиалаар ч тэр, сая 2, 3 өдрийн энэ хуралдаанаас бид нар ерөнхийдөө харж байна шүү дээ янз янзын, хэд хэдэн хуультай холбоотойгоор маргаанууд их өрнөж байгаа. Тэгэхээр энэ нь эргээд нийгэмд бас буруу, зөрүү ойлголтууд өгөх явдлууд бас байгаад байна. Ийм үед яах аргагүй Ёс зүй, дэгийн хороо энэ дээр тэр хуулийнхаа үндсэн зарчмыг барьж байгаад, тэр ёс шударга ёсныхоо зарчмыг барьж байгаад яг энийг нь сайхан зөв, буруугаар нь ялгаж өгөх ийм үүргийг бид нар нийгмийн өмнө хүлээх ёстой байх гэж би бодож байна.

Ер нь энэ төсвийн тодотголын тухай ингээд танилцуулга хийж байх явцад гарч байгаа энэ маргаантай асуудлууд дээр, яг энэ үндсэн зарчимд зарчмыг зөрчөөгүй юм гэдэг тал руугаа

энэ яг зарчмын дагуу энэ хийгдэж байгаа, гарч ирж байгаа саналууд явагдаж байгаа юм гэдгийг бид нарт бүүр ултай суурьтайгаар тодорхой сайхан хэлж өгөөч. Энийг нь бид нар бас цаашаа сонгогчдодоо бас нийгэмд хүргэе гэсэн ийм бодолтой байна. Асуулт гэхээсээ илүүгээр би өөрийнхөө байр суурийг илэрхийлэхэд тийм байна. Ялангуяа манай Ёс зүй, дэгийн байнгын хорооны үүрэгт энэ зайлиггүй хамаарах ёстой гэж бодоод байна.

**Б.Баярбаатар:** Санал гэж ойлголоо. Хэрлэн гишүүн ээ ойлголоо бас зөв өө зөв. Энэ талаас нь бид нар дотроо ярилцаж, Байнгын хороон дээрээ бас ярилцах нь зөв болов уу гэж бодож байна.

Дараагийн танилцуулга Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав аудиторын микрофоныг өгөөрэй. Хэдэн номер вэ? 3 уу? 3 номерын микрофон.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, Дэгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

15.05 цаг

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байгаа юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт 11 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байгаа.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Ерөнхий аудитор Загджав танд баярлалаа.

Асуулт асуугаад дуусчихсан. Одоо санал хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүн байна уу?

Үг хэлэх гишүүн байхгүй байна гэж үзье.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу Байнгын хорооны гишүүдээс?

Байхгүй байна гэж үзье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй учраас санал хураалт явагдахгүй. Ингээд анхны хэлэлцүүлэг Байнгын хороо хийж дууслаа.

Төсвийн байнгын хороонд Баасанжаргал гишүүн дүгнэлт танилцуулъя.

Ажлын хэсэгтээ баярлалаа.

**Баасанжаргал гишүүн? Лодой гишүүн танилцуулчих уу? Лодойсамбуу гишүүн танилцуулчих. Лодойсамбуу гишүүн мэдээлэл хийнэ Байнгын хорооны хуралдаанд.**

**Ч.Лодойсамбуу:** Өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Байнгын хорооны даргын байгуулсан ажлын хэсэг өглөө хуралдаж ярилцаад ерөнхий дүгнэлт гаргасан. Ерөнхий дүгнэлтээ өдөр Нарантуяа-Нара гишүүнд танилцуулсан.

Өглөө бид нар хуралдаад Байнгын хорооны гишүүд юун дээр, ажлын хэсгийн гишүүд юун дээр санал нэгдсэн бэ гэхээр энд асуудал нь хэлэлцэгдэж байгаа гишүүн маань үндсэндээ Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн тодорхой заалтыг зөрчсөн байна. Дээр нь Их Хурлын тодорхой журмыг зөрчсөн байна. Зарим гишүүдийн зүгээс санал гарсан. Баасандорж даргын явуулсан дүгнэлт, санал дээр, манай Байнгын хороо руу ирүүлсэн санал дээр эш татсан хуулиуд, хуулийн заалтууд, тэдгээр хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэхгүй байна гэж миний хувьд бол үзээгүй гэдэг саналаа хэлсэн.

Учир нь тэр заалтуудын, 3 заалт байсан. Тэр 3 заалт дээр Их Хурлын гишүүний нэр хүндийг ашиглаж үйл ажиллагаа явуулсан байна гэдэг заалт байсан. Энэ бол би тэгээгүй гэж үзсэн. Яагаад гэхээр гишүүн болохоос өмнө хийдэг байсан юмаа л үргэлжлүүлээд хийж байгаа учраас. Бусдаар бол дүрэм, журам бол зөрчсөн байна гэж ийм нэгдсэн дүгнэлтэд хүрсэн. Тэгээд эцсийн хэрхэх талаар Байнгын хорооны гишүүд маань хэлэлцэж шийдвэр гаргана.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүнээс, ажлын хэсгээс нэмэлт Баасанжаргал гишүүн.

**Х.Баасанжаргал:** Бид хэдийн зүгээс ажлын хэсгийн гишүүд дотроо уулзаж хуралдаад тодорхой шийдвэр

гаргахаас гадна бас эрх ашиг нь хөндөгдөж байгаа учраас Нарантуяа-Нара гишүүнтэй өөртэй нь уулзаж бас ийм шийдвэр дүгнэлтэд хүрч байгаагаа өөрт нь амаар танилцуулсан.

Нарантуяа-Нара гишүүний хувьд бол бас тодорхой хэмжээний ийм ёс зүйн зөрчил гаргасан гэдгээ юуны өмнө хүлээн зөвшөөрч байгаа.

Хоёрдугаарт бас хэд хэдэн зүйл дээр гомдолтой байна гэдгийг бас хэлсэн байдаг. Энийг бас би протокол дээр тэмдэглээд үлдээчих нь бол зөв гэж бодож байна.

Нэгдүгээрт, яг энэ Баасандорж даргын гаргасан энэ албан бичиг олон нийтэд өөрт нь хүрэхээс өмнө олон нийтэд цацсанд, цацагдсанд гомдолтой байна гэсэн ийм зүйлийг нэгдүгээрт хэлсэн.

Хэдийгээр нөгөө шийдвэр гаргаж байгаа ч гэсэн аль тал талын нөгөө байр суурь бид нарын протокол дээр тэмдэглэгдэх учраас хэлж байгаа.

Хоёрдугаарт гэвэл Баасандорж даргын албан бичиг дээр 2 өдрийн хурал тасалсан гэж бичсэн байсан. Би сүүлийн 2 дахь өдрийн буюу 19-ний өдөр, 19-ний өдрийн хурлын үдээс хойш 3 цагийн хуралд бол ирж оролцсон. Тэгэхээр 2 бүтэн өдрийн хурал би таслаагүй гэдгээ бол бас хэлж ийм тайлбарыг бол хэлдэг.

Гуравдугаарт гэвэл бас яг тэр нөгөө өмнө нь уулзаж Нарантуяа-Нара гишүүнтэй уулзсан талаараа албан бичиг дээр дурдсан байдаг. Баасандорж даргын зүгээс. Би тэгэхдээ нэрээр нь хэлчихжээ уучлаарай. Албан тушаалаар нь уг нь хэлэх ёстой байх тээ? Тэгээд энийг бол Нарантуяа-Нара гишүүний хувьд бол зүгээр нөхөрсөг байдлаар зөвлөж байна гэж би тухайн үедээ ойлгосон. Яг ийм албан ёсны ийм эрх зүйн үр дагавар үүсгэхүйц хэмжээнд надад анхааруулаа, тэгээд дараа нь энэ нь өөрөө ингээд нотлох баримт болоод ингээд ийм бичиг

дээр ингэж тусна гэж бас бодоогүй ээ. Тэгэхээр энэ тал дээр бас тодорхой ийм, тодорхой, илүү тодорхой хэлсэн ч гэдэг юм уу, илүү ийм зөвлөх, чиглүүлэх ийм чиг үүргээ аягүй сайн ингэж яасан бол би бас ийм зүйл дээр бас алдахгүй байх байлаа гэдэг ийм зүйлийг, ийм 3 зүйлийг бол бас хэлсэн гэдгийг бас гишүүний өөрийнх нь тайлбараас бас энэ протоколд бол тэмдэглэх нь зүйтэй.

Тэгэхээр бас цаашид ч гэсэндээ бид нар бусад гишүүддээ бас энэ зүйлийг анхааруулахаас гадна бид нар бас ер нь манай бусад гишүүд бас нийгэмд эерэг, зөв ойлголт өгөхийн тулд анхаарах зүйлүүдээ бас энэ дээрээс бас олж харах байх гэж бодож байна. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Асуулттай гишүүн Хэрлэн гишүүн. Өөр асуулттай гишүүн байгаа юу? Лодойсамбуу гишүүн.

Хэрлэн гишүүнээр эхэлье.

**Б.Хэрлэн:** Ер нь бид нар бас бидний л нэг Улсын Их Хурлын гишүүний асуудлыг ярьж байгаа тохиолдолд нэгдүгээрт өөрийг нь байхад нь өөртэй нь ингээд, өөрийг нь байхад нь энэ асуудлыг яривал өшөө илүү, арай жоохон хүнлэг байх байсан болов уу гэж яагаад ч надад тэгж бодогдож байна.

Хоёрт нь миний энэ хэлэх гэсэн бас дараагийн нэг юм ер нь ямар нэгэн байдлаар ийм алдаа, зөрчил гарлаа гэхэд заавал эхлээд ингээд албан ёсны шууд арга хэмжээ рүү явчлалгүйгээр Ёс зүй, дэгийн байнгын хорооноос, эсвэл Улсын Их Хурлын Тамгын газраас ганцаарчилж уулзах, хэлэх, сануулах, зөвлөх ийм юмнуудыг нэгдүгээрт урьтал болгож байвал яасан юм бэ? Хүний хамгийн эрхэм нандин юм тэр нэр хүнд гэдэг юм руу бас арай ч тэрийг жаахан хайрлаж, гамнаж ханддаг байх хэрэгтэй байна л даа. Тэгээд олон нийтэд тэр сүлжээгээр тэрийг тавина гэдэг бас үнэхээрийн зохисгүй зүйл болжээ гэж би хувьдаа бодож байна.

Хоёрдугаарт нь би бас энэ хугацаанд анзаараад байхад Нарантуяа-Нара гэж яваад байх юм. Тэр хүний иргэний үнэмлэх дээр, төрсний гэрчилгээ дээр Нарантуяа-Нара-гаараа явдаг юм уу? Аан за тэгвэл яг тэр дээр нь яг бичигдсэн дээр нь л цөмөөрөө хэрэглэж байхгүй бол бас сошиалаар бас ингээд анзаарч байхад яагаад Нара-гаар нь дуудаад байгаа юм гэх жишээтэйгээ юмнууд явж байна лээ л дээ.

Тэгэхээр миний зүгээр хэлэх гэж байгаа зарчмын байр суурь бол хамгийн нэгдүгээрт өөрсдөө эхлээд ганцаарчилж уулздаг байя, өөрийнх нь асуудлыг ярьж байгаа тохиолдолд заавал биечлэн өөрийг нь оролцуулж байлгадаг байя гэдгийг дараа дараагийнхаа үйл ажиллагаанд анхааръя гэж хэлмээр байна.

**Б.Баярбаатар:** Нээлттэй явж байгаа. Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Энэ түрүүн бас Төрийн албаны зөвлөлийнхөн орж ирсэн байхад бид нар ярьж байсан ёс зүйн асуудлуудыг, ёс суртахууныг хэрхэн сайжруулах вэ гэдэг тухай, ер нь ёс суртахууны асуудлуудыг эрх зүйн аргаар шийдэж болно гэж итгэдэг. Тэгээд тэр шийдэх гэж ямар нэгэн зүйл гаргаж тавьдаг нь өөрөө эргээд тэр гаргасан босгыг нь л давж байвал бусдаар яаж ч болно гэдэг ийм энэ ёс суртахууны асуудлуудыг юм болгоныг ингэж өгүүлбэр болгоноор нь, үйлдэл болгоноор нь ингэж хязгаарлах үнэхээр боломжгүй, хүн төрөлхтөн тэрний араас гүйгээд явж амжихгүй.

Тэгэхээр өнөөдөр манай Их Хурлын Тамгын газар бол үндсэндээ би энэ бол бичигдсэн дүрмийг мөрдүүлэх нь зөв. Гэхдээ нэг зүйл эхлүүлчихлээ гэж. Тэгээд би энэ Их Хурлын Тамгын газрын дарга Баасандоржид бас хэлж байгаа юм, яг одоо өөрөө эхлүүлсэн шүү. Тэгэхээр энэ хүний лайв /live/ ярьсан шигээ өнөөдрийн парламент өнөөдрийн Засгийн газрын гишүүд дотор бизнестэй тэрнийхээ эрх ашгийг бүр ил цагаан

яриад явдаг сайд нар хэвээрээ байгаа. Өнгөрсөн парламентын гишүүдийн, өнгөрсөн Засгийн газрын, өмнөх Засгийн газрын гишүүдийн хуучин бичлэгийг сөхөж тавиад байна лээ. Тэр бол боломжгүй. Тэр бол өмнөх парламент, өмнөх Засгийн газар.

Тэгэхээр энэ парламентын гишүүн байгаа, тэгээд давхар хавсарсан бизнес хийдэг тэрийгээ ил цагаан яриад явдаг ингээд явж байгаа гишүүд ил байгаагаас нь оруулж ирээрэй. Одоо энэ Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүний хувьд олон нийттэйгээ нийлээд энийг тэр Их Хурлын Тамгын газрын даргаас нэхээд явна. Ер нь энэ Их Хурлаас нэхээд явна, Байнгын хорооны даргаасаа бас нэхээд явна, хамтдаа ингээд явна. Энийг нь эхэлчихлээ шүү дээ. Одоо лайв-аар /live/ хувцас өмслөө гээд бид нар арга хэмжээ авах гэж байна шүү дээ. Хууль дээр байгаа юу? Байгаа. Нэгэнт ингээд өндөр хэмжээнд тавьчихаж чаддаггүй, зохицуулах боломжгүй юмыг зохицуулах гэж оролдох нь өөрөө эргээд ийм, хэдэн онд билээ хэлж байсан хэрэгждэг хууль баталмаар байна гэдэг шиг.

Тэгэхээр бид нар араас нь ямар гишүүнийг яаж оруулах юм? Байнгын хорооны гишүүд өөрсдөө санал гаргаж болдог юм уу, болдоггүй юм уу? Эс үгүй бол Их Хурлын Тамгын газрыг шахалтад оруулдаг юм уу ямар ч байсан өнөөдрийн парламентад байгаа давхар ажил эрхэлж байгаа гишүүд, сайд нарын асуудлыг араас нь оруулж ирээд ярилцаад явъя.

Тэгэхгүй бол ингээд ийм ялгамжтай байдал үүсгэж байгаа юм шиг ийм нөхцөлийг бий болгож байгаа юм. Тэгэхээр юм эхлүүлнэ гэдэг өөрөө аливаа асуудлыг гаргаж тавина гэдэг дараа нь хожмын үр дагаврыг нь бодохгүй бол болдоггүй. Тэгэхээр Их Хурлын Тамгын газар нэгэнт эхлүүлсэн, тэгээд эхлүүлсэн учраас гүйцээгээрэй гэдгийг бас дахин дахин хэлье гэж байгаа юм. Тийм.



**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүнтэй ер нь санал нэг байна шүү би. Одоо Бид нар энэ Байнгын хороо, манай Байнгын хороо шаардлага өндөр тавьж байж л энэ парламентын ёс суртахууны асуудал, парламентын гишүүний ёс суртахууны асуудлыг бид нар гаргаж ирж тавина. Өөр арга байхгүй. Ер нь бол энэ зан заншлын эрх зүй, энэ ёс суртахуун, энэ хуульчилж болдоггүй хэдэн зүйлүүд байдаг юм л даа. Хуульчлах гэж оролдохоор нөгөөх нь бүүр ингээд тойроод яваад байдаг тийм яг мөнгөн ус шиг баригддаггүй зүйл байхгүй юу ерөөсөө энэ ёс суртахуун гэдэг зүйл чинь. Яг зөрчихсөн юм уу гэхээр зөрчихсөн юм шиг, зөрчихсөн байна гээд үзэхээр зөрчөөгүй юм шиг. Тэгээд хэнд ч гэсэн л ер нь алдаа, дутагдал гаргадаг л ийм л юм байгаа.

Ёс зүйн дүрэм гэж байгаа. Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм гэж байгаа. Энэ дүрмийн 10.4 дүгээр зүйлд гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хэн ч гаргаж болно. Байнгын хороон дарга хүлээн авч, Байнгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар өгнө гэж байгаа юм. Ингээд гишүүн гомдол, мэдээлэлтэй холбогдсон гишүүнтэй уулзаж, тайлбар саналыг нь сонсож, тэмдэглэл хөтлөх, гишүүн шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа, материалыг гаргуулж авах, гишүүн шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох мэдээ, мэдээллийг гаргуулж авна. Шалгалтын явцад гишүүний ёс зүйн зөрчлийн шинж байдал нь ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Байнгын хорооны дарга тухайн гишүүнийг дуудаж уулзан зөвлөгөө өгнө.

10.6-д нь шалгалтын явцад гомдол, мэдээлэлд дурдсан гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл шалгалтын дүнг Байнгын хорооны даргад танилцуулна гэсэн ийм дүрэмд заасан зүйл явж байгаа.

11.1 дээр Байнгын хороо гишүүний ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг Монгол Улсын Их Хурлын тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэж, ёс зүйн зөрчлийн шинж байдлыг нь харгалзан дараах сахилгын хариуцлага ноогдуулна.

11.1.1-д сануулга өгөх, 11.1.2-т уучлалт гуйхыг үүрэг болгох, 11.1.3-д албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах гэж ийм 3 санкцтай. Ингээд энийгээ бид нар тооцохдоо тогтоол гаргана. Байнгын хорооны тогтоол гарна гэсэн үг. Тогтоол гарна гэсэн үг.

Тэгэхээр би 4 гишүүнээс бүрдсэн шалгалтын бүрэлдэхүүнээс надад сая хариуцлагынх нь санкцыг санал болгоогүй байна. Тэгэхээр энийг Лодойсамбуу гишүүн нэмээд тайлбарлах уу та?

**Ч.Лодойсамбуу:** Саналаа хэлчихье хариуцлагын санкц дээр нь. Би бол энэ дээр уучлалт гуйлгах хариуцлагыг ноогдуулъя гэж бодож байна. Ийм саналтай байна. Тэр ямар хэлбэрээр уучлалт гуйж яадаг нь энэ яаж журамладаг юм тэр журам байхгүй бол хэдүүлээ бас хэлэлцэх байлгүй дээ. Сонгогчдоосоо л уучлалт гуйна шүү дээ. Үгүй, сонгогчдоосоо л уучлалт гуйна шүү дээ. Энэ ёс зүйн дүрэм бид нар тангараг өргөсөн тангаргаа зөрчсөн гэх нь хаашаа юм, ёс зүйн алдаа гаргасан байна гээд сонгогчдоосоо л уучлалт гуйна л даа. Тэрнээс бид нар ингээд сануулдаг ч юм уу, эс үгүй бол бусад ийм торгуулийн арга хэмжээ авах нь зохимжгүй байна гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Одоо ийм л байгаа юм л даа ерөөсөө. Нийгэм яг энэ тал дээр ингээд дотроо хуваагдал үүсчхэж байгаа байхгүй юу. Нарантуяа-Нара гишүүний буруу гэсэн нэг хэсэг байна. Нөгөө талдаа бас буруу ч биш шүү дээ гэсэн нэг ийм хэсэг байна.

Тэгэхээр уучлал гуйх нь зөв байхгүй юу. Одоо энэ чинь үр дүн нь тийшээгээ гарах ёстой байхгүй юу. Энэ танхим дотор биш байхгүй юу. Энэ танхим дотор бид нар сануулаад ч юм уу, цалингийн 20 хувь яана гэдэг бол тэр хүнд ноогдуулж байгаа хэлбэр. Энэ танхимдаа үлдэнэ.

Олон нийтээсээ, тэр мэдээж энэ гомдол, санал чинь олон нийтийн дургүйцлээс үүсэж орж ирсэн гомдлууд шүү дээ. Тэгэхээр тэр олон нийтээсээ л уучлал гуйх ёстой болов уу гэж би бол харж байна. Тийм.

Энхтуяа гишүүн.

**Д.Энхтуяа:** Өдрийн мэнд хүргэе. Хоцорч орж ирсэн учраас уучлаарай бас өөр Байнгын хороотой байлаа.

Энэ өдөр бид нар Нара гишүүнтэй уулзаад тэгээд өөрөө бол бүх тайлбараа хийсэн. Бид нарын хэлэхдээ бол яг энэ бид нарт өгсөн энэ албан бичгээр бол 2 асуудал дээр бол энэ хариуцлага алджээ. Тэр нь нөгөө зөвшөөрөлгүй гадагшаа явсан, нөгөөдөх нь болохоороо хэн нэгэн гуравдагч этгээдийн бизнесийг дэмжсэн гэдгээр нь хийж болохгүй гэсний ийм хариуцлагын юу байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нь ямар нэгэн хариуцлага ноогдуулах тийм юм байгаа юм уу? Тэр ард иргэдээсээ уучлалт гуйх гэдэг бол энэ бол хувь хүний өөрийн гаргаж байгаа уучлал. Тэгээд ер нь бол парламентын гишүүний хувьд энэ парламентын өнгө төрх ч гэсэн ард түмнээс сонгогдсон учраас энэ хүн ард түмэндээ хандах нь бол гишүүнийхээ ёс зүйн хариуцлагыг хүлээгээд ард түмэндээ хандаж уучлалт гуйх нь бол энэ бас зүйн хэрэг байхгүй юу. Тэгэхээр энэ хариуцлагадаа орж байгаа юм уу? Энэ 3 хариуцлагадаа орж байгаа юм уу гэсэн ийм тодруулга байна.

**Б.Баярбаатар:** Орж байгаа.

**Д.Энхтуяа:** Ер нь бол Нара гишүүн бол өөрөө уучлалт гуйгаад ингээд ойлгоод яваад байгаа. Тэгээд энэ парламент, энэ залуу гишүүд алдаа гаргасан тэрийгээ бас ухаараад, энэ хариуцлагаа хүлээгээд, уучлалт гуйж байгаа гэдэг бол хүн ёсны харилцаа, нийгмийн бас соёлт юу гэж би хараад байна л даа.

**Б.Баярбаатар:** Ёс суртахууны соёл байхгүй юу энэ бол. Үндсэндээ асуулт, санал нэг дор яваад дууслаа.

Ёс зүйн дүрмийн дагуу Байнгын хороо тогтоол батална. Тогтоолын төслөө бид нар бэлдэж одоогоор яагаагүй учраас хариуцлагынхаа нэгдүгээрт тогтоолд ийм ийм гомдлууд ирсэн, ийм эх сурвалж нь ийм байгаа юм.

Хоёрдугаарт, ийм ийм бүрэлдэхүүнтэй ажиллаад үзэхэд, өөртэй нь уулзаж ингээд холбогдох шалгалтыг хийхэд ийм ийм хуулийн ийм ийм зүйл, заалтуудыг зөрчсөн байна. Энийгээ тухайн хүн өөрөө бас хүлээн зөвшөөрч байна гэдэг зүйлийг ингэж хэлээд.

Гуравдугаарт, холбогдох дүрэм, журмын дагуу хариуцлага буюу олон нийтээс, ард иргэдээсээ уучлалт гуйхыг ингээд үүрэг болгосон ийм 3 зүйлтэй тогтоолыг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Маш их юм асуусан шүү дээ. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулаадахъя эхлээд.

6 гишүүн зөвшөөрч, 66.7 хувиар санал хүчингүй боллоо.

Би өөрөө горимын санал гаргачихгүй юу. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя гээд.

Өөрчилъе гэхээсээ илүү өөртэй нь уулзъя гэсэн юм яриад байх шиг байна.

Болно. Лодойсамбуу саналаа хэлчих протоколтой тийм.

**Ч.Лодойсамбуу:** Энэ хар аа зөвхөн энэ Нарантуяа-Нара гэдэг хүний асуудал биш байхгүй юу. Энэ Байнгын хорооны үйл ажиллагаа, тэгээд анхны хурал, тэгээд анхны ёс зүйн асуудлыг хэлэлцэж байгаа жишиг тогтох гээд байна шүү дээ. Тэгэхээр бид нар хаашаа юм ингээд шийдвэр гаргахдаа нөгөө хүнээсээ чамайг яаж шийдэх вэ гэж асуух юм уу цаашид бүх хүнээс? Бүх хүнээс? Та нар хариуцлага тооцмоор байгаа хүнийхээ царайг бод доо. Тэгээд тэр хүнээс хариуцлага тооцох гээд тэгээд очоод асуух юм уу?

Тэгэхээр бид нар жишээлбэл, сануулга ингээд өнгөрлөө гэж бодъё. Энэ бараг нөгөө хүндээ энэ сануулга гэхээсээ илүүтэй уучлалт гуйх нь илүү бараг дээр нөхцөл байдал үүснэ. Сануулга үүсчихээр нийгэм юу гэж хүлээж авах вэ гэхээр юу сануулж байгаа юм, тэгээд яах юм, ингээд толгой илдэг юм уу гэдэг нэг талдаа. Энэ чинь бас буруу гэж үзэж байгаа хүмүүс байгаа шүү дээ сонгогчид дунд нь. Тэгэхээр хамгийн хөнгөн, хамгийн хөнгөн шийтгэлийг бид нар санал болгож байна. Хамгийн хөнгөн шийтгэлийг санал болгохдоо бид нар дараа дараагийн асуудлыг авч хэлэлцэх боломжтой нь нөхцөлөөр л хийх гэж байна шүү дээ. Тэгэхгүй бол бид нар дараа дараагийн хүмүүст хариуцлага ярьж чадахаа болино шүү дээ.

Жишээлбэл, зөвшилцөөд л эхэлбэл тэгээд л зөвшилцөөд л явна шүү дээ. Зөвшилцлийг больё л гэж энэ шийтгэл оногдуулах тухай ийм заалттай дүрэм байна. Тэгээд энэ үйл ажиллагааны зарчим нь байж байна шүү дээ энэ Байнгын хорооны. Тийм биз дээ? Тэгэхээр зөвшилцөх шаардлагагүйгээр би хувийн саналаа хэлж байгаа шүү дээ. Зөвшилцөх ямар ч шаардлага байхгүй. Тэртээ тэргүй өөрөө олон нийтээс уучлалт гуйж байгаа. Энийг нь албан ёсоор албажуулаад л авчихъя л гэдэг ийм санал тавьж байгаа.

**Б.Баярбаатар:** Санал хураалт явуулна. Санц дээрээ санал хураалт явуулна. Эндээс Баасанжаргал гишүүн бол сануулах гэдэг юуг санал болгож байна гэж ойлголоо.

Ажлын хэсэг та 4 хүний бүрэлдэхүүн яваад уулзаад явчихсан гэдэг чинь болж байгаа байхгүй юу. Үгүй үгүй Байнгын хороо шийдвэрээ гаргана. Байнгын хороо шийдвэрээ гаргана. Тийм, одоо бид нар та бүхний саналаар санал хураалт явуулна.

Нэгдүгээрт, Лодойсамбуу гишүүн бол уучлалт гуйх гэдэг хариуцлагыг тооцъё гэсэн.

Баасанжаргал гишүүн сануулах гэдэг хариуцлагыг тооцъё гэсэн энэ дээр эхлээд санал хураагаад л шийднэ.

Рэгдэл гишүүн микрофоноо асаагаад ярина шүү.

**Д.Рэгдэл:** Юун дээр бид хэд яриад ер нь ийм ийм зөрчил байна, тэгэхдээ зэрэг энэ зөрчлийг үндэслээд ер нь Байнгын хороонд бид нар сануулах арга хэмжээ авах саналыг оруулна гээд хэлчихсэн юм байгаа юм. Ерөөсөө хэлэхийн хувьд Нара гишүүнд. Тэгэхээр зэрэг бид нар уул нь яах вэ хоцорч, зөрж явсаар байгаад жаахан будилчихлаа л даа. Түүнээс бид нар бол ингээд л сануулах арга хэмжээ авахыг ажлын хэсгээс Байнгын хороонд оруулна л гэхчихсэн.

Тэгэхээр зэрэг сануулах гэдэг дээрээ саналаа хураах юм уу, яах юм? Бараг сануулах дээр нь хураасан нь дээр байх.

**Б.Баярбаатар:** Одоо юу яая сануулах, өөрийг нь байлцуулах шаардлагагүй ээ. Тэгэхээр Байнгын хороон дээр хэрэггүй. Тэртээ тэргүй та нар уулзаад асуудлыг нь сонсчихсон учраас дахиж Байнгын хороон дээр дуудаад, бид нар ямар Улсын Их Хурлын

гишүүнээс нь эгүүлэн татах гэж байгаа асуудал биш шүү дээ энэ чинь. Тэр тохиолдолдоо л өөрийг нь байлцуулдаг тийм механизм байдаг. Бусад зүгээр ийм захиргааны хариуцлага хүлээлгэх гэж байгаа, хууль хэрэгжүүлэх гэж байгаа л асуудал шүү дээ. Ер нь манай Байнгын хороо бол хуулийн хэрэгжилтийг л хангаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол заавал өөрийг нь байлцуулах шаардлага байхгүй гэж харж байна. Тэгэхээр санал хураалт явуулна.

Лодойсамбуу гишүүний гаргасан уучлалт гуйх, гуйлгах гэдэг саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Олон дэмжвэл зөвшөөрөгдөнө, дэмжигдээгүй тохиолдолд сануулах санкц руугаа шууд шилжинэ гэсэн томьёоллоор санал хураалт.

Хэрэлдэхгүй. Хөөе хэрэлдэхгүй, санал хураалтаар шийднэ асуудлаа. Санал хураалтаар шийднэ. Санал хураалт, саяын санал хураалт чинь угаасаа болсонгүй энэ төхөөрөмжүүд нь ч явсангүй, дүн нь ч гарсангүй.

Тэгэхээр санал хураалтаа дахиж хураана.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүний саналаар санал хураалт явуулна. Төхөөрөмж нь, нэг туршилтын санал хураалт явуулах уу? Тэр нь болохгүй байна. Төхөөрөмж нь. Эс үгүй бол солиод өөр юун дээр суучих. Зүгээр яриад л, хуруугаа хийгээд л болоо. Хажуу талд нь хуруугаа хийгээд л болоо.

Санал хураалт, санал хураалт.

Саналаа хураагаад шийдчихье л дээ. Битгий хэрэлд л дээ та нар. Тийм энэ санал хураалтын төхөөрөмж ажиллаадахвал саналаа л хураачихъя л даа. Тэгээд л болоо шүү дээ.

Томьёоллоо би дахиж хэлнэ. Лодойсамбуу гишүүн уучлалт гуйлгах санкцыг буюу хариуцлагыг ноогдуулах нь

зүйтэй гэсэн саналыг гаргасан. Энэ саналыг дэмжсэн томьёоллоор санал хураалт явуулна. Хэрвээ дэмжигдээгүй тохиолдолд ажлын хэсгийн бусад гишүүдийн гаргасан сануулах гэсэн хариуцлага руу шууд шилжиж орно гэсэн үг. Тийм. Санал хураалт шууд.

Би ил санал хураалт явуулна. Дэгт байгаа учраас. Харин тийм эндээс та хоёр гаргачих. Лодой гаргах юм уу, Ариунзаяа гарах уу? Ариунзаяа гишүүн гаргачих. Ариунзаяа гишүүний микрофоныг өгөөрэй.

**А.Ариунзаяа:** Төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас хэдүүлээ гар өргөөд энэ асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд гараар санал хурааж болно гээд заалт байгаа учраас Дэгийн хуулиа бариад Ариунзаяа гишүүний саналыг дэмжье гэсэн санал хураалт хийе.

Хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь горимын санал дэмжигдлээ. Ингээд санал хураалтаа илээр явуулна. Илээр гар өргөж явуулна.

Томьёоллоор би дахиад хэлье. Лодойсамбуу гишүүний гаргасан уучлалт гуйх хариуцлагыг ноогдуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжиж санал хураалт явуулна. Дэмжсэн гишүүд гараа өргөнө. Дэмжээгүй олонх давах юм бол уг Улсын Их Хурлын гишүүнд ноогдуулах сануулах хариуцлагын санкц нь үйлчилнэ гэдгээр ингээд явчихъя. Лодойсамбуу гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулчихъя.

3 хүн дэмжсэн санал өглөө. 4 хүн татгалзаж уг асуудал дэмжигдсэнгүй.

Ингээд тогтоолд Нарантуяа-Нара гишүүнд сануулах арга хэмжээ авахаар. Яах вэ энэ ингээд шууд энэ



*дэмжихгүй тал нь сануулах дээрээ  
яачхаж байгаа байхгүй юу. Тийм  
дуусчихсан.*

*Өнөөдрийн Байнгын хорооны  
хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж  
дууслаа. Та бүхэнд баярлалаа.*

*15.41 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*